# ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний барааны үнийн 2019 оны*
*I сарын 23-ны өдрийн ажиглалт*

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2019 оны I сарын 4-р долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 26 нэрийн барааны үнэ тогтвортой, 0 нэрийн барааны үнэ буурсан, 6 нэрийн барааны үнэ өссөн байна. Үүнд :

| ≈ Үнэ тогтвортой | ⇩ Үнэ буурсан | ⇧ Үнэ өссөн |
|---|---|---|
| • "Алтан Тариа" задгай гурил дээд | | • Сүү, задгай |
| • "Алтан Тариа" задгай гурил I | | • Цагаан будаа, “Заантай” |
| • "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд | | • Хонины мах, ястай |
| • "Алтан Тариа" савласан гурил дээд | | • Хонины мах, цул |
| • "Алтан Тариа" савласан гурил I | | • Үхрийн мах, цул |
| • "Алтан Тариа" савласан гурил II | | • Байцай, монгол |
| • “Сүү” ХК хайрцагтай 1 л сүү | | |
| • “Сүү” ХК савласан 0.5 л сүү | | |
| • Тараг, Цөцгийтэй | | |
| • Талх, "Атар" | | |
| • Талх, “Зууван чех” | | |
| • Талх, “хөх тарианы хар” | | |
| • Шар будаа | | |
| • Цөцгийн тос, Сүү ХК | | |
| • Ургамлын тос, “Янта” | | |
| • Ногоон цай, “Стимо” | | |
| • Элсэн чихэр, “Заантай” | | |
| • Үхрийн мах, ястай | | |
| • Адууны мах, ястай | | |
| • Ямааны мах, ястай | | |
| • Төмс, монгол | | |
| • Лууван, монгол | | |
| • Хүрэн манжин, монгол | | |
| • Сонгино, хятад, бөөрөнхий | | |
| • Алим, фужи | | |
| • Өндөг, ОХУ | | |

## Махны дундаж үнэ

2019 оны I сарын 4-р долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 7290 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 9010 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад тогтвортой, харин үхрийн цул махны үнэ 115 төгрөгөөр (1.0%) өссөн байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 8200 төгрөг, Харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 9500 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг



Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

**Үхрийн ястай мах**

| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2013 | 7 335 | 8 025 | 7 895 | 8 330 | 8 380 | 8 275 | 8 225 | 7 710 | 7 825 | 7 245 | 7 115 | 7 280 |
| 2014 | 7 980 | 7 775 | 8 425 | 8 370 | 8 685 | 8 730 | 7 955 | 7 590 | 7 635 | 7 550 | 7 495 | 7 465 |
| 2015 | 7 415 | 7 565 | 7 810 | 8 080 | 8 145 | 8 445 | 7 985 | 7 230 | 7 005 | 5 975 | 5 620 | 5 520 |
| 2016 | 6 165 | 6 875 | 7 105 | 8 170 | 8 495 | 7 930 | 6 950 | 6 865 | 6 120 | 5 235 | 5 495 | 5 580 |
| 2017 | 6 775 | 7 405 | 7 785 | 7 985 | 8 230 | 7 905 | 7 725 | 7 375 | 7 250 | 6 945 | 6 710 | 6 505 |
| 2018 | 6 615 | 7 110 | 7 740 | 8 365 | 8 465 | 8 735 | 9 085 | 8 225 | 7 780 | 7 845 | 8 005 | 8 305 |
| 2019 | 9010* | | | | | | | | | | | |

**Хонины ястай мах**

| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2013 | 6 480 | 7 095 | 7 060 | 7 420 | 7 490 | 7 470 | 7 415 | 6 710 | 6 540 | 6 215 | 6 085 | 6 245 |
| 2014 | 6 855 | 6 675 | 7 040 | 7 630 | 7 800 | 7 685 | 7 030 | 6 585 | 6 395 | 5 965 | 5 835 | 5 940 |
| 2015 | 5 860 | 6 140 | 6 735 | 7 460 | 7 555 | 7 455 | 6 830 | 6 050 | 5 540 | 4 510 | 4 200 | 3 930 |
| 2016 | 4 625 | 5 495 | 5 970 | 6 935 | 6 945 | 6 525 | 5 780 | 5 605 | 4 940 | 4 250 | 3 945 | 4 390 |
| 2017 | 5 650 | 6 030 | 6 675 | 7 080 | 7 235 | 6 700 | 6 575 | 6 395 | 6 210 | 5 760 | 5 380 | 5 140 |
| 2018 | 5 240 | 5 945 | 6 560 | 7 290 | 7 490 | 7 515 | 7 535 | 6 980 | 6 415 | 6 440 | 6 690 | 6 695 |
| 2019 | 7290* | | | | | | | | | | | |

* 4-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг




Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 50 төгрөгөөр (0.7%), хонины цул махны үнэ 135 төгрөгөөр (1.8%) тус тус өссөн байв. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 6700 төгрөгөөр, харин “Таван-Эрдэнэ” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 8000 төгрөгөөр худалдаалж байна.

## Гурилын үнэ



2019 оны I сарын 4-р долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1250-1500 төгрөг, 1-р зэргийнх 1000-1200 төгрөг, 2-р зэргийнх 800-1000 төгрөг байна.

Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1250-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.

Зураг 3. Будааны үнэ, 1 кг




Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг






“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1200-1320 төгрөгийн үнэтэй байна. “Баянзүрх”, “Бөмбөгөр”, “Барс”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1200 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетад хамгийн өндөр үнээр буюу 1320 төгрөгөөр худалдаалж байна.



Сар шинийн баярын ширээний ууцны дундаж үнэ 240000 төгрөг байна. 2018 оны сар шинийн баярын өмнөх үеэс ууцны үнэ 6.7 хувиар буюу 15000 төгрөгөөр өссөн байна.

Овор хэмжээ бага ууцыг “Хүчит Шонхор” зах дээр 150000-160000 төгрөг, дунд хэмжээний ууцыг 180000-220000 төгрөг, том овор хэмжээтэй ууцыг 250000-330000 төгрөгөөр тус тус худалдаж байна.



Цагаан сарын баярын ширээний тавгийн гол идээ болох хэвийн боовны үнэ нэг ширхэг нь дунджаар 2608 төгрөг байна.

Хамгийн хямд үнэтэй хэвийн боов нь “Бусад” үйлдвэрийнх, хамгийн өндөр үнэтэй нь “Атар Өргөө” үйлдвэрийнх байна. Хэвийн боовны үнийн ялгаа нь харагдах өнгө зүс, амт, чанараас шалтгаалж байна. 2018 оны цагаан сарын баярын өмнөх үеэс хэвийн боовны үнэ 20.2 хувиар буюу 438 төгрөгөөр өссөн байлаа.

Хүснэгт 2. Хэвийн боовны дундаж үнэ, төгрөг, 2014-2019 оноор

| | 2014<br>01.22 | 2015<br>02.11 | 2016<br>02.03 | 2017<br>02.15 | 2018<br>02.07 | 2019<br>01.23 |
|---|---|---|---|---|---|---|
| Ширхэг | 2035 | 2120 | 1955 | 2062 | 2170 | 2608 |
| 15 ширхэг | 30525 | 31800 | 29323 | 30930 | 32550 | 39123 |
| 21 ширхэг | 42735 | 44520 | 41052 | 43302 | 45570 | 54772 |

Хүснэгт 3. Ууцны дундаж үнэ, төгрөг, 2014-2019 оноор

| Үнийн хязгаар | 2014 01.22 | 2015 02.11 | 2016 02.03 | 2017 02.15 | 2018 02.07 | 2019 01.23 |
|---|---|---|---|---|---|---|
| Дээд | 400000 | 315000 | 260000 | 265000 | 290000 | 330000 |
| Доод | 125000 | 145000 | 125000 | 120000 | 160000 | 150000 |

## Хүнсний ногооны үнэ

2019 оны I сарын 4-р долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол байцай 0.8 хувиар өсөж 1200 төгрөгөөр худалдаалагдаж байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг




## Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2019.I.23

Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны XI, XII сар, 2019 оны I сар

Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2013-2019 оны I сарын 23

Хавсралт 4. Хэвийн боов, хонины ууцны дундаж үнэ, 2019.I.23

Хавсралт 5. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2019.I.23

Хавсралт 6. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны XI, XII сар, 2019 оны I сарын ажиглалтаар

Хавсралт 7. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2018-2019 он

Хавсралт 8. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2019.I.23